

## Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)

### Өрөмдлөгийн талаархи шинэчилсэн мэдээлэл

ДТ-4 цооногийг босоо чиглэлээр 2,020 метрийн гүнд хүртэл өрөмдөж, эрсдэл тооцоогүй нийт 21 сая баррель нөөц бүхий Баруун Давсан Толгой хэмээх хагарлын блокын нэг хэсэг дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцийг судлах юм. Энэхүү талбай нь 2010 онд ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудыг өрөмдсөн Давсан Толгойн үндсэн хэсэг болон түүний мэдээлэгдсэн геологийн нөөцөөс салангид талбай юм.

ДТ-4 цооногийг 1,271 метрийн гүнд, завсарын хэсгийн ёроол хүртэл өрөмдөөд байна. Одоогоор агаарын температур  $-20^{\circ}\text{C}$  хэмээс дээш байгаа бөгөөд цаг агаарын урьдчилсан мэдээгээр цаашид  $-20^{\circ}\text{C}$  хэмээс дээш байна хэмээн үзэж байна. Ийм нөхцөлд өрөм болон өрмийн ажилтнуудын аюулгүй ажиллагааны хэм хэмжээ зөрчигдөж байгаа тул Компани өрмийн зөвлөх add ips energy pty ltd болон өрмийн туслан гүйцэтгэгч DQE International компаниудтай зөвлөлдөж, өрөмдлөгийг түр зогсоох шийдвэр гаргав.

Өрөмдлөгийг хэвийн горимоор зогсоож ажлыг цаашид дахин үргэлжүүлж болохоор тохиромжтой түвшинд үлдээлээ. Цооногийн бичиглэлийг одоогийн гүнд хүртэл хийсэн бөгөөд завсарын хэсгийн яндангийн бэхэлгээ, цементлэх ажлууд хийгдсэн. Цооногийн баганыг найдвартай бэхэлсэн бөгөөд агуулагч давхаргад хараахан хүрээгүй байна. Өрмийг тайлбайд үлдээж, өвөлжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Өрөмдлөгийг 2011 оны 04 дүгээр сараас үргэлжлүүлнэ гэж үзэж байна

2010 онд амжилттай хэрэгжүүлсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ шинжилгээний ажил хийгдэж байна. ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудын өрөмдлөгийн үр дүнд тулгуурлан Давсан Толгойн мэдээлэгдсэн геологийн нөөцөд дахин үнэлгээ хийх боломжтой болох юм. 3 хэмжээст сейсмийн судлагааны мэдээллийг дахин боловсруулах, зураглах, мөн өмнө хийгдсэн эрсдэлийн судлагааны үнэлгээг дахин хийх зэрэг ажлууд хийгдэж байна. Эдгээр үнэлгээний дараа Бие даасан нэр хүнд бүхий зөвлөх мэргэжилтнээр дээрхи үнэлгээний ажлуудыг нягтлан хянуулах ажлыг ирэх хавраас өмнө хийж дуусгана.

“DQE International компанийн ажилчид цаг агаарын хүнд хэцүү нөхцөлд өрмөө маш сайн ажиллуулж, манай өрөмдлөгийн ажлыг үргэжлүүлэх боломжийг нэг сараар сунгаж өглөө. Бид ирэх хавраас өрөмдлөгийг эрт эхлүүлж, дээрхи байдлаар сайн ажиллаж чадвал бага хэмжээний нэмэлт зардлаар өрөмдлөгийн ажлын хугацааг хоёр сараар сунгах боломжтой болох юм.”

“ДТ-4 цооногийн өрөмдлөгийг бидний судлахаар зорьж буй формацийн дээд хэсэгт зогсоосон бөгөөд энэ түвшинд бид өрөмдлөгийг даруй үргэлжлүүлж, формацийн талаархи мэдээллийг шууд авахад илүү дөхөм болж байна” гэж Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас Жэй МакГэй мэдэгдлээ.

Мэдээллийг хянан тохиолдуулагч нарын анхааралд:

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны XX талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспект Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

**Петро Матад Лимитэд**

Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)

+976 11 331099

**Уэстхауз Секьюритиз Лимитэд**

Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)

+44 (0)20 7601 6100